



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 5/704

Улаанбаатар хот

**Н.Уугантуяагийн туршилтын хугацааг  
дуусгавар болгон албан тушаалд  
томилох тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Төрийн албаны тухай хуулийн 27.1.3 дахь заалт, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 472 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2021 оны 90 дүгээр тогтоол, Авлигатай тэмцэх газрын 2021 оны 05/9108 тоот албан бичгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Наранбаатарын Уугантуяагийн туршилтын хугацааг 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрөөр дуусгавар болгон үүрэгт ажлаас чөлөөлж, мөн өдрөөс Дундговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгчээр томилсугай.

2. Н.Уугантуяад 30/1-24 дугаартай улсын бүртгэгчийн тэмдэг хэрэглэхийг зөвшөөрсүгэй.


3. Н.Уугантуяагийн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд нэвтрэх эрхийг нээхийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар /Б.Ариунболд/-т даалгасугай.

4. Албаны нууцтай танилцах эрх олгон, төрийн болон албаны нууц задруулахгүй байх баталгааг гаргуулж, холбогдох хууль тогтоомжийг танилцуулахыг нууц хамгаалах ажилтан /Ж.Өлзийжаргал/-д үүрэг болгосугай.

5. Н.Уугантуяагийн албан тушаалын цалинг төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээний ТЗ-6-1-д хамааруулж, хоол унааны нөхөх зардлыг холбогдох журмын дагуу тус, тус тооцон олгохыг Дундговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс /Ж.Өлзийжаргал/-т зөвшөөрсүгэй.

6. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

571002558